ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2020/2021 Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 12

## ЕБС-ийн 12 дугаар ангийг 34.8 мянган сурагч өдрөөр суралцан төгсжээ

Бүх шатны сургуулийг 2020/2021 оны хичээлийн жилд 130.7 мянган суралцагч төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 79.8 мянган сурагч, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 19.7 мянган суралцагч, их, дээд сургууль, коллежийг 31.2 мянган оюутан тус тус төгсжээ (Зураг 1).

ЕБС-ийг өдрөөр төгсөгчдийн 44.9 мянган нь суурь боловсрол (9 дүгээр анги), 34.8 мянга нь бүрэн дунд боловсрол (12 дугаар анги) эзэмшигчид байна. 12 дугаар ангийг өдрөөр төгсөгчид өмнөх оны хичээлийн жилээс 6.3 мянга буюу 21.9 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД, сургалтын байгууллагын ангиллаар, мянган хүн




Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2020/2021 оны хичээлийн жилд 19.7 мянган оюутан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс 847 (4.5%)-гоор нэмэгдсэн байна. Нийт төгсөгчдийн 55.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД, хүйсээр

| Үзүүлэлт | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 | 2020/2021 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **19 531** | **20 544** | **21 206** | **18 887** | **19 734** |
| Эмэгтэй | 7 634 | 7 579 | 8 366 | 8 590 | 8 839 |
| Техникийн боловсрол | 2 398 | 1 690 | 2 521 | 2 460 | 2 084 |
| Эмэгтэй | 962 | 579 | 1 140 | 1 242 | 790 |
| Мэргэжлийн боловсрол | 12 154 | 16 318 | 13 499 | 14 263 | 17 085 |
| Эмэгтэй | 4 579 | 5 996 | 5 449 | 6 351 | 7 800 |
| Мэргэжлийн сургалт | 4 979 | 2 536 | 5 186 | 2 164 | 565 |
| Эмэгтэй | 2 093 | 1 004 | 1 777 | 997 | 249 |

Техникийн болон мэргэжлийн байгууллагын төгсөгчдийг мэргэжлийн чиглэлээр харахад 5.8 мянга (29.4%) нь аж үйлдвэрийн, 4.0 мянга (19.2%) нь барилга, 2.5 мянга (12.7%) нь тээврийн чиглэлээр төгссөн нь тэргүүлэх салбарууд байна. Төгсөгчдийн мэдээллийг хүйсээр авч үзвэл уул уурхайн чиглэлээр төгсөгчдийн 81.9 хувь, барилгын чиглэлээр төгсөгчдийн 78.4 хувь, тээврийн чиглэлээр төгсөгчдийн 77.3 хувь, аж үйлдвэрийн чиглэлээр төгсөгчдийн 44.3 хувь, үйлчилгээний чиглэлээр төгсөгчдийн 14.9 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗУРАГ 2. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр




Их, дээд сургууль, коллежийг 2020/2021 оны хичээлийн жилд нийт 31.2 мянган оюутан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс 3.1 мянга (11.1%)-аар өсжээ.

ХҮСНЭГТ 2. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙГ ТӨГСӨГЧИД, боловсролын зэргээр, хүйсээр

| Боловсролын зэрэг | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 | 2020/2021 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **34 681** | **29 164** | **23 038** | **28 045** | **31 161** |
| Эмэгтэй | 21 179 | 17 476 | 13 513 | 17 262 | 19 861 |
| Диплом | 495 | 45 | 409 | 268 | 117 |
| Эмэгтэй | 364 | 17 | 68 | 96 | 90 |
| Бакалавр | 30 301 | 25 120 | 18 951 | 23 081 | 25 727 |
| Эмэгтэй | 18 379 | 14 932 | 11 195 | 14 112 | 16 056 |
| Магистр | 3 772 | 3 868 | 3 574 | 4 531 | 5 273 |
| Эмэгтэй | 2 374 | 2 446 | 2 185 | 2 959 | 3 687 |
| Доктор | 113 | 131 | 104 | 165 | 44 |
| Эмэгтэй | 62 | 81 | 65 | 95 | 28 |

Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн мэргэжлийн тэргүүлэх чиглэлийг харахад бизнес, удирдахуй, хууль, эрх зүй, боловсрол тэргүүлж байна. Төгсөгчдийг хүйсээр авч үзэхэд инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр төгсөгчдийн дийлэнх (70.1%) нь эрэгтэй, бусад салбарын хувьд эмэгтэйчүүд нь дийлэнх байна.

ЗУРАГ 3. ДОТООДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙГ ТӨГСӨГЧИД, мэргэжлийн чиглэлээр, хүйсээр




## Ойлголт, тодорхойлолт

### Боловсрол

Ерөнхий мэдлэг, ур чадвар, чадамж олж авах, зан чанарын болон төлөвшлийн хувьд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, үнэлэгдсэн байр суурьтай болох насан туршийн үйл ажиллагааг ойлгоно.

### Сургалтын байгууллага

Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 3.1.5-д заасны дагуу боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг хэлнэ.

### Ерөнхий боловсролын сургууль

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай хууль”-д заасны дагуу боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага юм.

### Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага

Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 14 дэх зүйлд зааснаар политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв зэрэг хэв шинжтэй байж болох бөгөөд политехник коллеж нь техникийн боловсролын сургалт эрхэлдэг байгууллага байна.

### Дээд боловсролын сургалтын байгууллага

Монгол Улсын “Боловсролын тухай хууль”-ийн 15.1-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж энэ ангилалд багтана.

Эх үүсвэр

Боловсрол, шинжлэх ухааны яам
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ангилал, код

Монгол Улсын боловсролын түвшний ангилал

Мэдээлэл авах холбоос

http://www.nso.mn/
http://www.1212.mn/

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 1 дүгээр сарын 17

Нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн
газрын статистикч М.Доржпагма
Утас: (976-51)-263966